# Үндэсний энгийн гадаад паспорт захиалах

Бичсэн Administrator
2010 оны 1-р сарын 29, Баасан гариг, 10:21 -

Элчин сайдын яам гадаад паспорт олгохгvй богоод иргэдийн хvсэлтийн дагуу vндэсний энгийн гадаад паспортыг Монгол Улсын Иргэний бvртгэл, мэдээллийн улсын товд захиалан авч огно. Үндэсний энгийн паспортыг захиалга авснаас хойш 2-3 сарын хугацаанд олгоно. Үндэсний энгийн гадаад паспорт захиалах иргэн дараах бичиг баримтыг эх хувиар нь бvрдvvлж огно.

1. Монгол Улсын Иргэний бvртгэл, мэдээллийн улсын товд хандаж паспорт олгохийг хvссэн тухай оргодол,
2. Иргэний vнэмлэх (Иргэний vнэмлэх байхгvй бол Монгол Улсын иргэний бvртгэл, мэдээллийн товийн Иргэний баримтын тов архивын лавлагаа. Энэ лавлагааг Гадаад хэргийн яамны Консулын газраар баталгаа хийлгэн, тус Элчин сайдын яамны +61 (2) 6286 6381 дугаарын факсаар ирvvлэх шаардлагатай),
3. Эзэмшиж буй vндэсний энгийн гадаад паспортын эх хувь,
4. Гэрэл зураг 4 ширхэг (цагаан фонтой, 3,5 х 4,5 см хэмжээтэй),
5. Паспорт захиалах хуудас 2 хувь